

<https://doi.org/10.69561/mjac.v25i48.3635>

Article | Fasc.19

Дээд монголын уртын дууны судлагдсан байдалд хийсэн шинжлэл

Ан.Номунсан

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
ORCID: <https://orcid.org/0009-0004-7444-0057>
Холбоо барих зохиогч: 869249684@qq.com

Хураангуй: Энэхүү өгүүллийг Дээд монголын уртын дууны судлагдсан байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор бичиж байна. Зохиогч миний бие 2018 онд Монгол Улсын Соёл урлагийн их сургуульд “Дээд монголын уртын дууг хуурдах арга барил” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан ба түүнээс хойш Дээд монголын уртын дууг гүнзгийрүүлэн судлах явцдаа уртын дууны өлгий нутаг болох Хөх нуурт 2017, 2019, 2020, 2023 онуудад хээрийн судалгаа хийж, тухайн орон нутагт болон Бээжин, Хөх хотод хэвлэгдсэн холбоотой ном бүтээл, өгүүлэлтэй танилцан, цуглуулж, уг бүтээлүүдэд ангилал хийн, нэгтгэн дүгнэсэн.

Судлагдсан байдлаас үзэхэд, Дээд монголын уртын дууны түүхэн холбогдол, төрөл зүйл, дуулах зан үйл, шүлэг, аялгууны хувилбар, өвлөн уламжлах, хадгалан хамгаалах талаар судалгаанууд түлхүү хийгдсэн байна.

Цаашид Дээд монгол уртын дууг язгуур шинж, бүтэц, уран сайхны онцлог гэх өргөн агуулгын хүрээнд судлах шаардлага байсаар байна.

Түлхүүр үгс: Дээд монгол, урт дуу, судлагдахуун, шинжлэл

Analysis of the study of long songs of Upper Mongolia

Nomunsan An

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
ORCID: <https://orcid.org/0009-0004-7444-0057>
Corresponding author: 869249684@qq.com

Abstract: This article is written for the purpose of analyzing the researched status of Upper Mongolian long songs. In 2018, I, the author, obtained a master's degree at the Mongolian University of Culture and Arts on the subject of “Musical techniques of long songs of Upper Mongolian long song with horse fiddled music”. Since then, in the process of in-depth study of the long songs of Upper Mongolia, I have conducted field research in 2017, 2019, 2020, and 2023 in Khukh Lake, the birthplace of long songs, and



have reviewed and collected books and articles related to long songs in that area and in Beijing and Hoh as well as classified and summarized them.

In accordance with the research, studies have been conducted on the historical significance of long songs of Upper Mongolia, their types, singing rituals, poems, and versions of melodies, inheritance, and preservation.

As well as, in the future, there is still a need to study the long songs of Upper Mongolia in the context of their roots, structure, artistic features and unique characters.

Keywords: *Upper Mongolia, long song, study, analysis.*

Оршил

Дээд монголын уртын дууны судлагдсан байдалд дүн шинжилгээ хийх зорилгыг хэрэгжүүлэхдээ тухайн судалгаатай холбогдох ном, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийг цуглуулах, төрөлжүүлэн ангилах, тоймлон бичих, үр дүнг нэгтгэн, асуудал дэвшүүлэх зорилтын хүрээнд хийлээ.

Судлаачдын судалсан байдлыг ерөнхийд нь үзвэл, Гэрэлт Дээд монголын уртын дууны түүхэн холбогдол, Лувсанжамба зан үйл, Товчдоо аман зохиол, Л.Үсрэнгүй, Эрдэнэчимэг нар төрөл зүйл, С.Баянжаргал дууны аялгуу, Цэвшиг шүлгийн хувилбар, Ч.Сэнгээ өвлөн уламжлал, Хөхшил газар нутгийн онцлог шинж, У.Цолмон тархцын талаас нь гэх мэт судалгаа шинжилгээнүүдийг хийсэн байдаг.

Эдүгээ Хөх нуур мужид хятад, монгол, төвөд, хотон зэрэг олон үндэстэн суурьшин амьдарч байна. Энэ нь өөр өөрийн өвөрмөц онцлог бүхий хэл соёл, дуу хөгжим гэх мэт олон зүйл хувьсах, өөрчлөгдөх сөрөг үзэгдэл үүсэх нөхцөл болж байгаа юм. Үүний хэрээр өв соёлыг үндсэн шинжээр нь авч үлдэх шаардлага тулгарч байна.

Иймд энэ байдалд шинжлэх ухаанчаар хандах, орхигдож, гээгдэж, хувьсаж байгаа зүйлүүдийг оновчлох, тодорхойлоход энэхүү өгүүллийн ач холбогдол оршиж байна.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг хийхдээ, Хөх нуур мужид дөрвөн удаагийн хээрийн судалгаагаар цуглуулсан ном, бүтээл, мөн Бээжин, Хөх хотод хэвлэгдсэн Дээд монголын уртын дуутай холбогдох бүтээлүүдийг цуглуулан, агуулгаар нь ангилал хийж төрөлжүүлэх, тоймлон бичих, үр дүнг нэгтгэн, асуудал дэвшүүлэх аргыг ашигласан болно.

Судалгааны үр дүн

Дээд монголын уртын дууны судлагдсан байдлыг

1. Түүхэн холбогдол, төрөл зүйл
2. Зан үйлтэй холбогдох дуу
3. Дууны шүлэг, яруу найраг
4. Аялгуу болон хувилбар
5. Дууны өвлөн уламжлал болон хадгалалт хамгаалалт гэх агуулгын хүрээнд ангилан үзэж болохоор байна.

Дээд монголын уртын дууны түүхэн холбогдол, төрөл зүйлийн талаар судалсан найман судлаачийн ном, өгүүлэл байна. Эдгээр нь Хөх нуур мужид хэвлэгдсэн бүтээлүүд юм.

Судлаач Л.Үсрэнгүй, Эрдэнэчимэг нарын найруулсан “Дээд монголын ардын дууны хувилбарын харьцуулсан эмхэтгэл” (2021) номд төрийн дуу болон шашны дууг эмхэтгэн судалж, хурим найрын дуу, магтаал дуу, хошигнол дуу, түүхт дуу, хөдөлмөрийн дуу, янагийн дуу, атаа маргааны дуу хэмээн ангилан, түүхт дуугаа дотор нь түүхэн хүний дуу, түүхэн үйл хэргийн дуу хэмээн хоёр төрөлд, хөдөлмөрийн дууг төл авхуулах дуу, ан агнуурын дуу, бүүвэйн дуу, эсгий тавих, ноос савдаг дуу зэрэг таван төрөл зүйлд, янагийн дууг хуучин, шинэ, атаа маргааны дууг таван хурууны болон арван хоёр жилийн гэх хоёр үндсэн төрөлд тус тус хуваасан бөгөөд Дээд монголын ардын дууны өв тээгчдийн талаар бүртгэн судалжээ. Энэ бүтээл нь судалгааны түвшний хувьд хээрийн судалгаанд тулгуурлаж, Дээд монголын ардын дууны аман сурвалжийг эмхэтгэж, харьцуулан судлах аргыг ашиглаж туурвиснаар Дээд монголын ардын дууны судалгааны ажилд ихээхэн хувь нэмэр оруулсан бүтээл болсон байна.

Судлаач Сэрэнгэрэлийн “Дээд монголд уламжлагдсан Ар богдын тухай ардын дуу” (2019) өгүүлэлд “Замбутивийн орон” гэх дуу нь Жавзундамба хутагттай холбоотой, түүнд зориулан дуулсан төдийгүй монголчуудын дунд Жавзундамба хутагтын хүндэтгэлийн байр суурь болон итгэл бишрэлийн хэмжээ нэлээд байна хэмээн үзжээ. Мөн Жавзундамба хутагттай холбоотой бусад ардын дууг судалж, дууны тархалт, төрөл зүйл, хувилбарын онцлогийн талаар өгүүлжээ.

Судлаач Гэрэлтийн “Хөх нуур Дээд монголын уртын дууны тухай миний өчүүхэн ойлголт” (2019) өгүүлэлд монгол уртын дууг угсаатны бүлгүүдээр нь төрөлжүүлж, Дээд монголын уртын дууны түүх, зан үйлийг тоймчлон үзэж, Дээд монголын уртын дуу болон төвөд ардын дууны харилцан нөлөөллийн талаар авч үзсэн байна.

Судлаач Б.Батбаярын “Ойрадын утуу дууг (уртын дуу) төрөл зүйлд хуваах асуудалд” (2019) өгүүлэлд ойрадын уртын дууг аялгуугаар “уртын дуу” болон “богино дуу”, агуулгаар нь “шастир дуу” болон “ерийн дуу” гэж хуваасан байна.

Судлаач Илжаагийн “Дээд монголын түүхт хүмүүсийн магтаал дууг туршин өгүүлэх нь” (2019) өгүүлэлд Лувсанданзан ба “Гасын цагаан дэрс” дууны түүхийн зохиогдсон түүхэн цаг үетэй нь холбон судалж, Шуунуу болон “Нарийн говийн зэргэд” дууг зохиогдсон түүхэн нөхцөл байдал, үйл хэрэгтэй нь уялдуулан үзэж, Буухай баатар ба “Алтан хангайн эхэн” дууг Буухай баатрын түүхэн үйл явдалд тулгуурлан судалжээ.

Судлаач У.Цолмоны “Дээд монголын зүүн хошууны ардын дууны тухай дөхөм ажиглалт” (2019) өгүүлэлд Дээд монголын ардын дууны аман уламжлал, бичгийн сурвалжийн тухай, мөн тухайн орон нутгийн зүүн хошууны түүхэн үе шат, ардын дууны уламжлал, төрөл зүйлийн талаар танилцуулж, найрын дуу, туульсийн дуу, лалий дуу, атга маргааны дуу, хөдөлмөрийн дуу зэрэг дуунуудын төрөл зүйл, онцлог шинжийг тус тус тодруулан гаргасан байна.

Хөхшилийн найруулсан “Дээд монголын төрийн дууны тухай судлал” (2019) номд Дээд монголын уртын дууг тоймчилсноос гадна Дээд монголын төрийн

дууны өвлөн уламжлагчдын удам судар, тархалтыг судалж, төрийн дууны уламжлалын бүс нутгийг долоон бүс нутагт хуваан ангилсан байдаг. Мөн төрийн дууны үүслийн түүхэн нөхцөл байдлыг баримт нотолгоотой нягталж, онцлог шинжээр нь язгуур монголын, орон нутгийн, цастын өндөрлөгийн, агуулгаар нь сайд ноёдоо, агт хүлэг морио дуулсан гэж үндсэн хоёр хуваан, урлагийн шинж, шүлгийн хэл хэллэг, уран зохиомжоор нь ураг хуримын, үсний болон насан баярын, их, бага найр наадмын гэх зэрэг өвлөгдөн дуулах орон зайд нь тулгуурлан судалснаас гадна дуулах цаг хугацааны талаас судлан, холбогдол бүхий зан үйл, бусад төрлийн дуутай харилцах хамааралд ажиглалт хийжээ. Тухайн бүтээл нь судалгааны түвшний хувьд төрийн дуу хэмээх ганц сэдвийн тойронд өв тээгчид, тархалт, төрөл зүйл, сэдэв агуулга, зан үйл гэх зэргийг холбон судалж, тодорхой хэмжээнд өргөн цар хүрээг хамруулснаар Дээд монголын уртын дууны судалгааны ажилд ач холбогдлоо өгч, сэдвийн хамаарлыг нарийсган, мөн чанарын хувьд гүнзгий судлах чиг хандлагыг гаргасан.

Товчдоогийн найруулсан “Дээд монголын хуримын ёс”, “Дээд монголын ардын аман зохиолын цуглуулга” (2010), “Дээд монголын янагийн дуу” (2003) гэсэн гурван бүтээл нь Дээд монголчуудын дунд түгээмэл дэлгэрсэн ардын дуунуудыг цуглуулан эмхэтгэж төрөлжүүлснээр Дээд монголын ардын дууны урын сангийн бүртгэлд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд судалгааны түвшний хувьд түүхийн, зан үйлийн, хөгжим судлалын гэх мэтээр эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж, шинжлэх ухааны үүднээс нягтлан судлахад үнэ цэнтэй гарын авлага, эх хэрэглэгдэхүүн болох талтай байна.

Дээд монголын зан үйлтэй холбогдох уртын дууны талаар дөрвөн судлаач гурван ном, нэг эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, Хөх нуур болон Бээжинд хэвлүүлжээ.

Судлаач Лувсанжамбын “Дээд монголын уламжлалт хурим, ардын дуу, ерөөл, магтаал” (2014) номд хуримын зан үйл, ураг төсөвлөх, аман занги ярих, сонсгол хэлэх, архи хадгаа хүргэх, амсгул хүргэх, зус хадаг хүргэх, бага хурим, алаши хурим хүргэх, дотоодын хурим хүргэх, их хуримд гүйцэтгэх ёс, шинэ айлын хөшиг тайлах ёс, хувь өгөх ёс зэрэг арван нэгэн зан үйлээр төрөлжүүлэн өгүүлжээ. Дээд монголчуудын уртын дууг есөн дэд бүлэгт хувааж,

- Нутаг ус
- Өвөг дээдэс удам судар
- Бурхан шашин
- Төр шашин
- Баяр найр
- Ураг хурим зэрэг зургаан сэдвээр төрөлжүүлжээ.

Мөн Дээд монголчуудын ерөөл, магтаалыг цуглуулж, баянсунгийн ерөөл, найрын ерөөл, хуримын ерөөл, монгол гэрийн ерөөл, монгол морины ерөөл, бусад зүйлийн ерөөл гэж зургаан хэсэгт ангилжээ.

Лин Юүй Шэний “Дээд монголын хуримын ёс” (2014) номд хонины хурим, баянсунгийн ёс заншил, хуримын бэлтгэл ёс үйл, бэр мордуулах, бэр буулгах, хүргэн мордуулах ёс заншил, ерөөл магтаалыг тус тус өгүүлж, Дээд монголын уртын дууг

- Төрийн дөрвөн дуу
- Шашны дөрвөн дуу
- Бэр мордох дуу
- Аяс сайхан арван дуу гэх зэрэг дөрвөн төрөлд төрөлжүүлэн эмхэтгэн судалсан байна.

Судлаач Товчдоогийн “Дээд монголын ардын аман зохиолын чуулга” (2010) бүтээлд Дээд монгол уртын дууг

- Түүхт дуу
- Хурим найрын дуу
- Янаг хайрын дуу гэж гурван зүйл болгон эмхэтгэн үзэж,
- Цацал мялаалга
- Сан даллага
- Тахилга тайллага
- Дом шившлэг зэрэг зан үйлээр дөрвөн зүйлд төрөлжүүлэн туурвижээ.

Судлаач Х.Бүрэнцэнгэлийн “Дээд монголчуудын ардын дууг хэрхэн судлан шинжлэх тухай дөхөм өгүүлэх нь” (2019) өгүүлэлд Дээд монголчуудын түүхэн үе шатыг тодруулж, ардын дууг нь таван төрөл зүйлд ангилан судалж, ардын дууг хэрхэн, яаж түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, уламжлан залгамжлах, дууны түүхийг мөшгөх, байгаль орчинтой шүтэлцүүлэх, зан үйлтэй уялдуулах, хэл хэллэг, үсэг бичгийг дээдлэх, хөг аялгууг судлах талаар үзэл бодлоо дэлгэрүүлж, саналаа дэвшүүлжээ.

Харин Дээд монголын уртын дууны шүлэг, яруу найргийн талаар судалсан долоон судлаачийн өгүүлэл, судалгааны ажлыг авч үзлээ. Эдгээр бүтээлүүд нь Бээжин, Хөх нуур, Хөх хотод хэвлэгдсэн байна.

Судлаач Цавшигийн “Дээд монголын ардын дууны зарим үг үсгийг тэмдэглэх, тайлбарлах зөвлөгөө” (2019) өгүүлэлд монголчуудын нутгийн аялгууг хүндэтгэж, түүнийг зөв ойлгосны суурин дээр Дээд монголын ардын дууг цуглуулж, дууны шүлгийн үгийг зөв оновчтой тэмдэглэх шаардлагатай тухай өгүүлжээ.

Судлаач Хөхшилийн “Дээд монголын төрийн дууны тухай анхны сүвэгчлэл” (2019) өгүүлэлд “Төрийн дуу гэдэг нь эзэн ноёдоо хүндэтгэж, эх нутгаа магтсан, хурим найрын эрхэм дээд үнэ цэнийг харуулсан, ая аялгуу нь уужим тэнүүн дуу болно” (Хөхшил 2019, 158) хэмээн тодорхойлсон байна.

Судлаач Чойжийн “Дээд монголын уртын дууны үгсийн сангийн тухай хэдэн шинжлэл” (2019) өгүүлэлд Дээд монголын уртын дууны сэдэв, уртын дууны нэр томьёо, учир холбогдол, шүлгийн үг, найруулгын талаар тайлбарлан өгүүлсэн. Түүнчлэн Дээд монголын уртын дууг дуулах хэв намба, байгаль, газар зүйн тогтоцтой холбон хийсэн ажиглалт, уртын дууны төрөл зүйл, хэл хэллэгийн талаар шинжилжээ.

Судлаач Ван Ций Ухаагийн “Хүлгийн шинж хэмээх уртын дууны тухай ойлголтоо туршин өгүүлэх нь” (2019) өгүүлэлд “Хүлгийн шинж” дууны шүлгийн хувилбарын талаар судалжээ.

Судлаач Дүгэрсүрэнгийн “Дээд монголын янагийн дууны тухай шинжлэл” (2019) өгүүлэлд Дээд монголын янагийн дууны хэв намба, шүлгийн хэл хэллэгийн талаар нарийн судалсан байдаг.

Судлаач Насан-Очирын “Дээд монголын ардын үлгэрт дуу Гасын цагаан дэрс

болон Буухай баатарт тусгагдсан урлагийн гоо сайхны тухай” (2019) өгүүлэлд дуу хөгжмийн уран сайхны утга илэрхийллийн талаар товчхон өгүүлж, “Гасын цагаан дэрс” дууны уран сайхны утга илэрхийллийг шүлэг зүйн талаас шинжилж, Буухай баатар дууны уран сайхны утга илэрхийлэл мөн шүлэг зүйн талаас авч үзсэн байна.

Судлаач Сүхбаатарын “Дээд монголын ардын дууны шинжлэл” (2019) өгүүлэлд Дээд монголын уртын дууг хэрхэн төрөлжүүлэх асуудлын талаар тайлбарлаж, Дээд монголын найрын дууны шүлэг, төрийн дууны шүлэг, шашны дууны шүлэг, хуримын дууны шүлэг, лалий дууны шүлгийг тус тус жишээ болгон өгүүлж, Дээд монголын ардын дууны талаар хийсэн ажиглалт, үзэл бодол, санал санаагаа дэвшүүлжээ.

Дээд монголын уртын дууны аялгуу болоод хувилбарын талаар судалсан дөрвөн судлаачийн таван өгүүлэл, судалгааны ажлыг авч үзлээ. Эдгээр бүтээлүүд нь Бээжин, Хөх нуур, Хөх хотод хэвлэгдсэн байна.

Судлаач С.Баянжаргалын “Ойрад монголчуудын дуу дууллагын “нахилгын” тухай асуудал” (2019) өгүүлэлд баруун монгол, дөрвөн ойрадын тархалт, түүхэн замнал, нутгийн аялгуу, хөгжимт соёлын тухай танилцуулжээ. Тэрээр уртын дуу дуулах урлаг дахь “нахилга”-ын гурван онцлог шинжийг өгүүлж, гуравдугаар хэсэгт “нахилга”-ын үндсэн хэлбэр болон “нугалаа”, “хугалаа”-ны хоорондох харилцан хамаарлыг өгүүлэхдээ ноотны жишээн дээр тулгуурлан системтэй ажиглалт хийж, хөгжим судлалын үүднээс авч үзсэн байна.

Судлаач Х.Бүрэнцэнгэлийн “Гасын цагаан дэрс хэмээх Дээд монголын уртын дуу” (2019) өгүүлэлд “Гасын цагаан дэрс” дууны дуулагдаж байгаа бүс нутаг, дууны түүхэн үйл хэрэг, аялгууны онцлогийн талаар өгүүлжээ.

Судлаач Б.Одонгавьяагийн “Дээд монголын цаст мөнгөн ая” (2019) өгүүлэлд Дээд монголын ардын дууны ая эгшгийн өвөрмөц онцлогийн тухай өгүүлж, ардын дууг нь долоон төрөл зүйлд хуваан, ардын дууг хэрхэн, яаж хамгаалах, хөгжүүлэх тухай гурван зүйлд тулгуурлан үзэл бодол, санал санаачилгаа дэвшүүлжээ.

Судлаач Сэргэлэнгийн “Дээд монголын уртын дууны илтгэх сэтгэлгээний тухай ойлголт” (2019) өгүүлэлд Дээд монголын уртын дууг илэрхийлэх сэтгэлгээний талаар тайлбарлан, уртын дууг зургаан төрөл зүйлд ангилж, сэтгэлгээний онцлог шинжийг тодруулын хамт баяр найрын уртын дууны, янагийн дууны, хөдөлмөрийн дууны сэтгэлгээний онцлог шинжүүдийн талаар тус тус судалжээ.

Дээд монголын уртын дууг өвлөн уламжлах, хадгалан хамгаалах талаар судалсан найман судлаачийн долоон өгүүлэл, нэг ном бүтээл байна. Эдгээр бүтээлүүд нь Бээжин, Хөх нуур, Хөх хотод хэвлэгдсэн байна.

Товчдоогийн “Дээд монголын янагийн дуу” (2010) номд Ренчин, Цэрэн, Сүх, Осор, Дүгэрсүрэн, Чулуу, Мам, Говь, Чогсом, Улаанбаатар, Чойр Жин, Өлзий, Алтантуяа, Чулуубаатар, Түмэн, Дашинзуу, Гужа, Бапули, Янжи, Цолмон, Алтансүвд гэх зэрэг ардын уран бүтээлчдийн талаар цуглуулан тэмдэглэсэн ба зохиосон янагийн дуунуудыг нь эмхэтгэн судалжээ.

Судлаач Ч.Чойдандарын “Ардын дууны уламжлалд холбогдох зарим асуудал” (2019) өгүүлэлд Ганьсу мужийн Сүбэй монголчуудын ардын дуугаар жишээлж, ардын дууны тархалт болон өв тээгчдийн тухай өгүүлжээ.

Судлаач Ч.Сэнгээгийн “Дээд монголын уртын дууг уламжлал хамгаалах

асуудалд” (2019) өгүүлэлд 2005 онд ЮНЕСКО-ийн монгол уртын дууг хүн төрөлхтний биет бус соёлоор бүртгэсэн болон БНХАУ-ын биет бус соёлын өвийн тухай хэрэгжүүлж буй бүхий л бодлогын дагуу 2009 онд Дээд монголын уртын дууг Хөх нуур мужийн Соёлын биет бус өв төлөөлөх чанартай бүтээлээр бүртгэж, уртын дууг хадгалж, хамгаалахад соёлын бодлого хөшүүргэ болж байгааг өгүүлж, БНХАУ-ын нам засгаас ардын уран сайханчийн үйлдлийг бадруулах, бүс нутгийн соёлын биет бус өвийг хамгаалах, уртын дуучныг хүндэтгэх, халамжилах, соёл урлагийн холбогдол бүхий албаны талынхан Дээд монголын уртын дууны нийгэмлэгийг зохион байгуулах, бага дунд ангийн хүүхдүүдэд уртын дууг зааж сургах, уртын дууны тэмцээн уралдааныг зохион байгуулах талаар санал дэвшүүлж, уртын дууны өв тээгчид хэрхэн яагаад цөөрч байгаа асуудлын тойронд санаачилга гаргажээ. Дээд монголын уртын дууг хамгаалахад уртын дуучдыг урьж, хоолойн бичлэг хийх, дууны шүлгийн үгийг тэмдэглэж эмхэтгэх, дуучдын намтар уран бүтээлийг цуглуулах тухай дэлгэрэнгүй өгүүлжээ.

Судлаач Үүлэнхуарын “Дээд монголын уртын дууны одоогийн байдал хийгээд уламжлан хамгаалах тухай” (2019) өгүүлэлд Дээд монголчуудын гарал үүсэл, Дээд монгол уртын дууны тархалт, төрөл зүйлийн тухай, одоо цаг үед уламжилж байгаа нөхцөл байдлын тулгамдсан асуудлын талаар өгүүлэхдээ Дээд монголын уртын дууны өв уламжлал алдагдаж байгаа нь түүний оршин буй байгалийн эвдэгдэл, даяаршлаас шалтгаалан эдийн болон соёлын үндэс, суурь алдагдсан гэж үзсэн нь бидний дээр өгүүлсэн “Дээд монголын уртын дууг уламжилж хамгаалах асуудалд” хэмээх өгүүлэлд гарсан Ч.Сэнгээгийн санал, үзэл баримтлалаас ялгаатай байна. Харин Дээд монголын уртын дууг хөгжүүлэхэд Дээд монголчуудын оршин амьдарч байгаа эх байгаль, нүүдэл соёлыг хамгаалах болон Дээд монголын уртын дууг сургуулийн сурган хүмүүжлийн заах хичээлд оруулах шаардлагатай гэсэн нь судлаач Ч.Сэнгээгийн дэвшүүлсэн Дээд монголын уртын дууг хамгаалах үзэл бодолтой санал нэгтэй байна.

Судлаач Хасцэцэгийн “Дээд монголын төрийн дуучин Хиагийн тухай анхны шинжлэл” (2019) өгүүлэлд Дээд монголын хурим найрын хүндэтгэлийн тоглолт эхлэхэд төр шашны гурван дууг төрийн дуучин Хиа нар эхлүүлэн дуулдаг ба дуучин Хиа нарыг улаан, ногоон, хөх жинст Хиа хэмээн нэрлэж байсан тухай, төрийн дуу, дуучны уламжлалын тухай тус тус өгүүлжээ.

Судлаач Үсрэнгүйн “Хөх нуурын Хайшийн монголчуудын ардын дууны дуулах зан үйл жич түүний уламжлал хамгааллын тухай” (2019) өгүүлэлд Хөх нуурын Дээд монголчуудын оршин амьдарч буй нутаг дэвсгэрийн хэмжээ, монгол хүн амын тоо, ардын дуу, домог туульсийн талаар товчхон өгүүлж, Хайши дахь монголчуудын ардын дууны өв сэргэлт, ардын дууг эмхэтгэн хэвлэсэн байдлыг тайлбарлаж, Хайши монголчуудын ардын дууны уламжлалын зан үйлийг хоёр хуваан, Хайши дахь монголчуудын өв соёлын наадам, ардын дууны уламжлал шинэчлэлийн талаар өгүүлжээ.

Судлаач Балжийн Бүргэдийн “Хөрлөг хошууны уртын дуу буюу миний сурвалжлах дурсамж” (2019) өгүүлэлд Хөрлөг хошууны бүс нутагт хээрийн судалгаа хийхдээ ардын дуу, өв тээгчдийн намтар, уран бүтээлийн талаар цуглуулан танилцуулсан байна.

Судлаач Мөнхийн “Дээд монголын зүүн хошууны уртын дууны тухай товч өгүүлэх нь” (2019) гэх өгүүлэлд зүүн хошууны түүхэн гарал үүсэл, уртын дууны өв тээгчид, уртын дууны төрөл зүйл, дуулах хэв намба, онцлог шинжийн тухай өгүүлжээ.

Судлаач Цүй Лин Линий “Хөх нуурын Тайжнар хошууны монголчуудын ёслолын дууны шинжлэл” (2006) номд Тайжнар хошууны монголчуудын түүх, соёл, зан заншил, дуу хөгжмийн төрөл, онцлог, тэр дундаа зан үйл дэх дууг шинжлэн судалсан талаар өгүүлсэн байдаг.

Судлаач Жү Хүй “Хөх нуур Дээд монголын ардын дууны соёлд хийсэн хээрийн судалгаа” (2019) өгүүлэлд Хөх нуурын Дээд монголын дунд уламжлагдаж байгаа ардын дууны талаар хятад, төвөд, хотон, уйгар, казак үндэстнүүдийн харилцан нөлөөллийн талаар судалсан байна.


Хэлэлцүүлэг

Эрдэмтэн судлаачдын өгүүллийн агуулгыг нэгтгэн үзвэл:

Хүснэгт 1

Ном, өгүүлэл	Тоо	Хувиар
Дээд монголын уртын дууны түүхэн холбогдол, төрөл зүйлийн талаар	8	25.8%
Дээд монголын уртын дуу дуулах зан үйлийн талаар	5	12.90%
Дээд монголын уртын дууны шүлгийн талаар	7	22.50%
Дээд монголын уртын дууны аялгуу болон хувилбарын талаар	5	12.90%
Дээд монголын уртын дууг өвлөн уламжлах, хадгалан хамгаалах	8	25.80%
Нийт	33	100%

- Дээд монголын уртын дууны түүхэн холбогдол, төрөл зүйлийн талаар
- Дээд монголын уртын дуу дуулах зан үйлийн талаар
- Дээд монголын уртын дууны шүлгийн талаар
- Дээд монголын уртын дууны аялгуу болон хувилбарын талаар
- Дээд монголын уртын дууг өвлөн уламжлах, хадгалан хамгаалах



Зураг 1. Дээд монголын уртын дууны талаар судалсан судлаачдын судалгааны ажлын агуулга

Дээд монголын уртын дууны судлагдсан байдлыг нэгтгэн тоймлож, судалгааны эргэлтэд оруулж, цаашдын судалгааны чиг хандлага, орон зай, учир дутагдалтай талыг илрүүлээ.

Дүгнэлт

Дээд монголын уртын дууны судлагдсан байдалд ажиглалт хийсний үр дүнд: БНХАУ, ӨМӨЗО-ны монгол судлаачдын Дээд монгол уртын дуутай холбогдох нийт 33 бүтээлтэй танилцаж, агуулгаар ангилан, тоймлон дүгнэж, эзлэх хувийг графикаар гаргав. Үүнээс дүгнэхэд,

1. Дээд монголын уртын дууг тухайн бүс нутгийн судлаачид түүх, зан үйл, аман зохиол, хувилбар, өвлөн уламжилж хамгаалах, өв тээгчид гэх зэрэг талаар ном бүтээлийн хэмжээнд судалснаараа Дээд монголын уртын дуу, түүний судалгааны хөгжилд давуу талтай байна.
2. Дээд монголын уртын дууг олон улсын эрдэмтэн судлаачид судалж, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулж байгаа нь шинжлэх ухааны ач холбогдлыг нэмэгдүүлж байна.
3. Дээд монголын уртын дууг хөгжим судлалын үүднээс судалсан ном зохиол, эрдэм шинжилгээний өгүүлэл цөөн байгаа нь Дээд монголын уртын дууны судалгааны сул тал төдийгүй, цаашид нэг сэдэвт бүтээл болгож эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Ашигласан материалын жагсаалт

- Дээд монголын соёл судалгааны нийгэмлэг. 2019. *Дээд монгол судлал*. БНХАУ, Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Лувсанжамба. 2014. *Дээд монголын уламжлалт хурим, ардын дуу, ерөөл магтаал*. БНХАУ, Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо.
- Жү Хүй. 2019. *Хөх нуур Дээд монголчуудын ардын дууны соёлд хийсэн хээрийн судалгаа*. БНХАУ, Хөх хот: Өвөр монголын урлагийн их сургуулийн сэтгүүл.
- Товчдоо. 2003. *Дээд монголын янагийн дуу*.
- Товчдоо. 2010. *Монгол ардын аман зохиолын цуглуулга*.
- Үсрэнгүй, Л., Эрдэнэчимэг. 2021. *Дээд монголын ардын дууны хувилбарын харьцуулсан эмхэтгэл*. БНХАУ, Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Хөхшил. 2023. *Дээд монголын төрийн дууны тухай судлал*. БНХАУ, Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Цүй Лин Лин. 2006. *Хөх нуурын Тайжнар хошууны монголчуудын ёслол болон дууны шинжлэл*. БНХАУ, Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Шэн., Лин Юүй. 2014. *Дээд монголын хуримын ёс*. Хөх хот: Өвөр монголын Соёлын хэвлэлийн хороо.